

## НЭВТРҮҮЛЭГ БЭЛТГЭН, ДАМЖУУЛАХ ГЭРЭЭ

2017 оны 02-р сарын 08-ний өдөр

№

Улаанбаатар хот

2017 02 08 004

### ӨМНӨТГӨЛ:

#### Нэг талаас:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны гудамж, 13Б байр хаягт орших, "Эрүүл мэндийн хөгжлийн төв" ХХК /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж, Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.НАРАНТУЯА

#### Нөгөө талаас:

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1-р хороо, Энгельсийн гудамж, Алтай хотхоны 13-р байр хаягт орших УБД: 9011334122, РД: 5569583 "Реал Мастер Линкс" ХХК-ийн "LIKE HD" телевиз /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, /хамтад нь Талууд гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий захирал Ч.Эрхэмбаяр

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Захиалагчийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг бэлтгэн, дамжуулахтай холбогдсон Талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллах нөхцөл журмыг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээнд Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 1.3 Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын хууль тогтоомж болон гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.
- 1.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт, хавсралт зэрэг нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнтэй нэгэн адил хүчинтэй байна.
- 1.5 Гэрээний хугацаа дуусгавар болоход аль нэг талын санаачилгаар хүсэлтээ бичгээр илэрхийлэн, талууд тохиролцсон тохиолдолд энэхүү гэрээний хугацаа дахин сунгагдсанд тооцно.
- 1.6 Гэрээний сунгалт болон хүсэлтийг нэмэлтээр гэрээнд хавсаргах бөгөөд 1.5-р заалтыг мөрдөнө.
- 1.7 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 2.1 Энэхүү гэрээ нь 2017 оны 02-р сарын 08-ны өдрөөс 2017 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл хүчинтэй байна.
- 2.2 Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
  - а. Талууд харилцан тохиролцсоноор,
  - б. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачлагаар,
- 2.3 Аль нэг тал нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд саналаа нөгөө талдаа ажлын 5 өдрийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 2.4 Гэрээг цуцлах тохиолдолд талууд гэрээг дүгнэн төлбөр тооцоо нийлж акт үйлдэнэ.

### ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО, СҮРТАЛЧИЛГАА

- 3.1 Гэрээний нийт төлбөр (1,500,000) (нэг сая таван зуун мянга)-н төгрөг байна. /Үүнд НӨАТ багтсан болно/
- 3.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ажлын 3 өдрийн дотор гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.





## **ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**


- 4.1 Гэрээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах баримт материал, түүний агуулга, хамтран ажиллах газар, мэргэжилтэн, санхүүжилтийн талаар захиалагчид шаардлага тавих эрхтэй.
- 4.2 Гүйцэтгэгч нь өөрийн бэлтгэсэн нэвтрүүлэг, мэдээллийг өөрийн эфирт нэвтрүүлсэний дараа гарч болзошгүй зохиол, зохиомжийн найруулга, зохиогчийн эрхийн талаарх маргаан, санал гомдол, хариуцлага, торгууль шийдвэр, шийтгэлийг хариуцах.
- 4.3 Гүйцэтгэгч нь захиалагч талын үйл ажиллагаа болон мэдээ, мэдээллийг нэг жилийн хугацаанд "ЦАГ ҮЕ-ЭРҮҮЛ МЭНД" мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулна.
- 4.4 Гүйцэтгэгч нь захиалагч талын захиалгат нэвтрүүлгийг "Эрүүл Монгол Хүн" нэвтрүүлэг "Эрүүл Оршихуй" хөтөлбөрт оролцуулах /Нэг дугаар тав хүртэлх минутаар /
- 4.5 Гүйцэтгэгч нь "Эрүүл мэндийн хөгжлийн төв"-ийн тухай 5 минутийн нэвтрүүлэг бэлтгэн өгөх.
- 4.6 Гүйцэтгэгч нь захиалагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.7 Гүйцэтгэгч нь захиалагчаас өгсөн реклам, зар сурталчилгаа, хөтөлгчийн аман сурталчилгааны эх файлд захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн засвар, өөрчлөлт оруулахгүй байх;
- 4.8 Гэрээний биелэлтийг хангах зорилгоор байнгын харилцах ажилтныг томилж, түүнийг өөрчлөх бүрт мэдэгдэж байх үүрэгтэй.
- 4.9 Гүйцэтгэгч нь Захиалагч талын, үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг техникийн болон эфирийн шаардлага хангасан түвшинд цаг хугацаанд нь нэвтрүүлэх үүрэгтэй.
- 4.10 Захиалагчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааны дуу дүрсний чанарыг эх хувиас дордуулсан, нэвтрүүлээгүй, дутуу нэвтрүүлсэн, хуваариас өөр цагт нэвтрүүлсэн тохиолдолд телевиз нь захиалагчид учирсан хохирол, зардлыг хариуцах бөгөөд үнэ төлбөргүй залруулан нөхөн нэвтрүүлэх үүрэгтэй.
- 4.11 Захиалгат ажлыг бэлтгэхэд шаардлагатай мэргэжлийн баг ажиллуулна. /зураглаач, найруулагч, редактор, хөтөлгч/

## **ТАВ. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1 Гэрээний биелэлтийг хангах зорилгоор байнгын харилцах ажилтныг томилж, өөрчлөх тухай бүрт мэдэгдэж байх;
- 5.2 Захиалагч нь гэрээний биелэлтэд хяналт тавих эрхтэй бөгөөд шаардлага хангахгүй, товросон хугацаанд гэрээнд заасан тоо хэмжээгээр цацагдаагүй тохиолдолд гүйцэтгэгч талд шаардлага тавих;
- 5.3 Захиалгат ажлын агуулга, чанар, хүртээмжид тогтмол хяналт тавьж, удирдлагаар хангаж, хийгдсэн бүтээл шаардлага хангаагүй бол сайжруулах, нэвтрүүлэхгүй байхыг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 5.4 Захиалагч нь өөрийн захиалгат нэвтрүүлгийг телевизийн эфирийн цагаар цацагдах цаг, хуваарийг сонгох болон Телевизтэй харилцан тохирох эрхтэй.
- 5.5 Энэхүү гэрээний дагуу бэлтгэгдсэн захиалгат нэвтрүүлэг, уран бүтээлүүдийн оюуны өмчийг эзэмших эрх нь Захиалагчид хадгалагдах ба хувиалан олшруулж түгээх болон бусад телевизээр давтан гаргах эрхтэй.

## **ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 6.1 Талууд гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх бөгөөд гүйцэтгээгүйн улмаас нөгөө талд учирсан хохирлыг 100% бүрэн хэмжээгээр хариуцан төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь харилцан тохиролцсон буюу гэрээнд заасан нөхцөл, журам, дамжуулалтын хуваарийг зөрчсөн буюу батлагдсан эх загвараас өөрөөр, алдаатай сурталчилсан эсвэл захиалагч талаас хамаарах шалтгаанаар дамжуулагдаагүй бол





Захиалагчтай талтай зөвшилцөн захиалгат ажил, сурталчилгааг үнэгүй нөхөн дамжуулна.

#### ДОЛОО. НУУЦ ХАДГАЛАХ

- 7.1 Энэхүү гэрээ нь Талуудын байгууллагын нууцад хамаарах тул гэрээний заалт, төлбөрийн хэмжээ, рекламны давтамжийн талаар аливаа гуравдагч этгээдэд гэрээний аль нэг тал мэдээлэхгүй, задруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 7.2 Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай (техник, санхүү гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгээр болон аман хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

#### НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ


- 8.1. Энэхүү гэрээнд хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдэн гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулсны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 8.2. Талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ 2 болон түүнээс дээш удаа биелүүлээгүй болон зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд аль нэг тал нь энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 8.3. Гэрээг нэг талын санаачилгаар цуцлах нөхцөл үүссэн тохиолдолд аль нэг тал нь энэ тухайгаа урьдчилан бичгээр мэдэгдэнэ.
- 8.4. Энэхүү гэрээний 8.2 болон 8.3-р зүйлд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан нь гэрээг дангаар цуцалж байгаа этгээдийн өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх, эрхээ хамгаалах, гэм хорыг арилгуулах эрхийг хязгаарлахгүй болно.

#### ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан нөхцөл байдлын улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг аль нэг тал нь нөхөн төлөхгүй.
- 9.2. Гэрээг 2 хувь үйлдэж, Талууд тус бүр 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 9.3. Талуудын эрх бүхий төлөөлөгчид өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээнд заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.4. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Б.НАРАНТУЯА

LIKE HD ТЕЛЕВИЗИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ч.ЭРХЭМБАЯР

И-мэйл: [likechannel\\_tv@yahoo.com](mailto:likechannel_tv@yahoo.com)

Утас: 99076359, 77055270